

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2018 ОНЫ ХОРИН НЭГДҮГЭЭР ХУРАЛДААН

Хуралдаан 2018 оны есдүгээр сарын 27-ны 14 цаг 00 минутад эхэлж, завсарлаж, 18 цаг 04 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д 4 цаг 04 үргэлжлэв.

	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтын захиалгын талаар танилцуулах	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатарын 2018 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн ХЭГ/2050, ХЭГ/2051 тоот тус тус албан бичгээр Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга зэрэг албан тушаалд томилогдох удирдах ажилтны нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах захиалга ирүүлснийг хэлэлцээд, сонгон шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2018 оны 10 дугаар сарын 29-ны өдөр зохион байгуулахаар шийдвэрлэлээ.
2	Эрүүл мэндийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яаманд хийсэн шалгалттай холбогдуулан гаргасан тогтоолын хэрэгжилтийн явцын талаар танилцуулах	Тэмдэглэлд тусгах
3	Шинэчлэн найруулсан Төрийн албаны тухай хуулийн дагуу батлагдах дүрэм, журмын боловсруулалтын талаар Зөвлөлийн хуралдаанд танилцуулах нарийвчилсан хуваарь	Тэмдэглэлд тусгах
4	"Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн төсөлтэй танилцах	Тэмдэглэлд тусгах
5	"Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны бүтэц, зохион байгуулалт, орон тооны дээд хязгаар"-ын төсөлтэй танилцах	Тэмдэглэлд тусгах
6	"Төрийн албан хаагчийн төлөөллийг сонгон шалгаруулах журам"-ын төсөлтэй танилцах	Тэмдэглэлд тусгах

7	"УИХ, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүх, Үндсэн хуулийн цэц, Улсын ерөнхий прокурорын газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Төрийн албаны зөвлөл, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Сонгуулийн ерөнхий хороо, Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний статистикийн хороо, Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалын ангилал, зэрэглэл"-ийн төсөлтэй танилцах	Тэмдэглэлд тусгах
8	"Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэл"-ийн төсөлтэй танилцах	Тэмдэглэлд тусгах
9	"Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам"-ын төсөлтэй танилцах	Тэмдэглэлд тусгах
10	"Маргаан хүлээн авч, хянан шийдвэрлэх журам"-ын төсөлтэй танилцах	Тэмдэглэлд тусгах

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
АЖЛЫН АЛБА**